

МОНГОЛ ТӨРИЙН ЛЕГИТМ, ЛЕГАЛЬ ШИНЖ

Ж.Урангуа

МУИС-ийн Түүхийн тэнхмийн багш, доктор /Sc.D/, профессор

Монгол Улс нь 1911-1915 онд бүрэн эрхт тусгаар улс, 1915-1919 онд ДИУ-ын харъяалалд автономит эрхтэй оршин тогтнож байсан юм.

XX зуун бол Монголчуудын сэргэн мандлын зуун байлаа. Өдгөөгөөс 101 жилийн тэртээ, билгийн тооллолын цагагчин гахай жилийн өвөл, аргын толлын 1911 оны арванхоёрдугаар сарын 29-ний өдөр Монголын шарын шашны тэргүүн, Өндөр гэгээний наймдахь дүрийн Жэвзүндамба хутагтыг Монгол Улсын эзэн, шашин төрийг хослон баригч хаанаар өргөмжлөн, Засгийн газраа таван яамтайгаар байгуулан, тусгаар улсыг сэргээн байгуулснаа ёслол төгөлдөр зарлан тунхагласан билээ.

Бидний ухаалаг өвөг дээдэс Дэлхий дахин болон бүс нутгийн хэмжээнд өрнөж буй хувиралт, гадаад таатай нөхцөл байдлыг соргог мэдэрч, ухаалаг овжин ашиглан үндэсний эрх чөлөөний тэмцлээ шинэ шатанд гарган зоримог хөдөлсөний ачаар тэртээ XVII зуунд Өмнөд Монгол Манжийн эрхшээлд орсон цагаас тоолбол 275 жил, Халх Монгол Манжид дагаар орсноос эхлэн тоолбол 220 жил, монголчуудын тусгаар төр улсын сүүлчийн гал голомт Ойрад Монголын Зүүнгарын хаант улс Чин улсад эзлэгдсэнээс тооцвол 155 жил улирсны эцэст тийнхүү баатарлаг тэмцсэний үр дүнд Монгол Улс дэлхийн тавцнаа дахин гарч ирсэн бөгөөд түүний ач холбогдол нь юутай ч зүйрлэшгүй. Тусгаар төр улсаа сэргээж, түүхэндээ анх удаа орчин цагийн танхимын зохион байгуулалттай ажилладаг байнгын Засгийн газраа байгуулсан, улмаар улсын хэргийг хэлэлцэн шийтгэх зөвлөлдөх эрх бүхий Дээд, Доод Хурлыг өнөө цагийн парламентын хэлбэрт нэлээд ойртуулан өөрийн хөрсөнд буулгасан гээд зөвхөн засгийн тогтсон ёсын талаас харахад бүхий л талаараа улс шиг улс болж тогтосон аж. Улмаар тусгаар тогтнолоо Орос, ДИУ болон дэлхийн бусад орнуудаар хүлээн зөвшөөрүүлж найрсаг харилцаа тогтоох, харилцан түншлэхийг эрэлхийлсэн бичгийг шийтгэн явуулж байлаа.

Монгол төрийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал буюу легитим чанар нь бүхий үйл явц дээр илэрч байлаа.

Манжийн эрхшээлийн үед монгол хэмээх угсаатны үндэсний нэгж байсан хэдий ч түүхч М.Санждоржийн бичсэнчлэн: "...өөрийн хаангүй, өөрийн засгийн газаргүй, өөрийн төр улсын нийслэлгүй болж, төрийн дээд бүх эрх мэдэл манж хаан, түүний төв засгийн газрын гарт бүрэн орсон байв. Монголд манжийн хатуу хяналт, заавар, хууль зүйлийн үндсэн дээр ажиллах орон нутгийн засаг засаглал л оршин байх" болжээ. Ийнхүү нийгмийн бааз суурьдаа тохирохгүй давхарга 200 гаруй жил Монгол оронд оршисоор байв. Энэ байдлаас гарах аян шалтгийг хайсаар XX зуунтай золгосон билээ. Манжийн эрхшээлээс гарах тэмцэл бол угтаа угтаа үндсээ чөлөөлөх тэмцэл юм. Тиймээс "Үндэсний чөлөөлөх хувьсгал" хэмээх томъёололд дараахь ойлголтыг хамруулж байна. Үндэстэн судлалын

модернист урсгалын онолч Эрнест Геллнер: “үндэстний үзэл бол ерөнхийдөө улс төрийн болон үндэсний нэгж давхцаж байх ёстой гэсэн улс төрийн зарчим юм” гэхдээ уг зарчмаа “төрийн эрх баригчид нь бусдаасаа салсан байх ёсгүй” гэсэн нөхцөл дээр л авч үзсэн билээ. Өөрөөр хэлбэл тэрбээр: “үндэсний үзэл нь угсаатны хил хязгаар улс төрийнхөөр хэрчигдсэн байх ёсгүй, ялангуяа тухайн улсын угсаатны хил хязгаар нь эрх баригчдыг бусдаас нь салгасан байх ёсгүй... гэсэн улс төрийн легитим үндэсийн онол юм” гэжээ. Орчин үед энэхүү онолыг баримтлан үндэстэн хийгээд үндэсний асуудлын судалгаа хийгдэж байгаа билээ.

1911 оны үйл явдал нь Монгол угсааны бүх хүн амыг нэгтгэн тусгаар тогтносон улс байгуулах зорилго бүхий тэмцэл байсан учир Геллнерийн дээр дэвшүүлсэн үндэсний үзлийн зарчимтай давхцаж байгаа юм. Чухам энэ үүднээс цагагчин гахай жил Монгол оронд өрнөсөн үйл явдлыг үндэсний гэж үзэж байгаа билээ. Мэдээж энэ үйл явдал нь угсаа гарлын хувьд нийтлэг нийт Монголчуудыг угсаа гарлын хувьд өөр Манж Чин улсын эзэрхийллээс чөлөөлөх явдал байсан учир тэр нь үндэсний чөлөөлөх үйл явдал болох нь илэрхий юм.

Нөгөө талаар хувьсгал гэдэг нэр томъёог хэрэглэхдээ засгийн эрхийн тухай асуудалыг уг үйл явдал хэрхэн шийдвэрлэсэнд анхаарал хандуулсан болно. Уг үйл явдал нь Монгол дахь Чингийн төрийн эрх мэдлийг халж Монголын тусгаар тогтносон бүрэн эрхт төр, улс байгуулан төрийн эрх мэдлийг “өөрийн хэргийн эрхээ бусдаар мэдүүлэхгүй өөрсдөө барина” хэмээн тунхаглан тэмцэж улмаар Монголчуудын мэдэлд авсан бөгөөд тэгэхдээ энэ үйл явдал нь тухайн үед Монгол-Манжийн харилцаанд үйлчилж байсан ямар нэгэн хууль дээр бус, харин Монгол нь угаас тусгаар улс байсан учир тусгаар улс байх ёстой гэсэн Монголын төрт ёсны түүхэн уламжлал дээр тулгуурласан шаардлага дээр үндэслэгдэн явагдсан болно. Нэгэнт уг үйл явдал нь Манж хааны Монголыг захирах эрх мэдлийг халж Монголчууд өөрийн хааныг өргөмжилж түүнд уг эрх мэдлийг шилжүүлсэн нь хэрэг дээрээ Манж нарын Монголыг захирах эрхийг устгасан төдийгүй Монголыг захирах улс төрийн эрхийг Монголчуудад олгосон бөгөөд тэгэхдээ тухайн үед үйлчилж байсан Манжийн хуулиас гадуур замаар хийсэн учир уг үйл явдлыг хувьсгал гэж үзэх нь илүү оновчтой байгаа юм. Улс төр судлалын шинжлэх ухаанд “аливаа хувьсгалын гол асуудал бол засгийн эрхийг авах явдал байдаг” хэмээн үздэг. Тэгвэл Их Хүрээнд байсан Манжийн захиргааг хөөн зайлуулж, монголчууд засгийн эрхийг гартаа авч өөрийн эзэн хаанаа өргөмжлөн, төр засгийг байгуулсан явдал нь энэхүү хувьсгал зорилтоо биелүүлснийг илтгэж байгаа явдал ажээ. Нөгөө талаар шинээр тогтсон улс төрийн засгийн легитимт шинж нь засгийг нийгмийн зүгээс зөв зүйтэй гэж үзэн нийгмийг удирдах эрхтэй хэмээн хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны шинжтэй чанар нь маш тод илэрч байсан юм. “Олноо өргөгдсөн” хэмээх тодотгол дээрх шинжийг нэгэн зэрэг илэрхийлж байгаагийн дээр тус орны баруун хязгаарын монголчууд Хүрээнд тогтсон засаглалыг хүлээн зөвшөөрсөн, Баруун болон Өвөр Монголын монгол туургатнууд түүнд дагаар орж байсан болон дагахыг хүсч байсан зэрэг үйл явдлууд нь дээрхийг нэгэн адил илтгэнэ. Засгийн легал шинж

нь тусгаар тогтнолоо тунхагласан анхны өдрөөс төрийн баримт бичигт хуульчлагдан тусгагдаж, эрх зүйн хэм хэмжээ болон баталгаажиж эрх зүйн шинж чанараа олсоноор илэрч байна.

Дээрх үндэслэлийг гаргахын зэрэгцээ нэгэн зүйлийг нэмж дурьдахад, ХХ зууны II хагаст Дэлхийн колонийн систем нуран унаж олон зуун жилээр харийн эрхшээлд, колони болон хагас колонийн байдалтай байсан олон оронд үндэсний эрх чөлөөний тэмцэл хөдөлгөөн өрнөж, колонийн дэглэмээс ангижирсан улс түмнүүд тийнхүү үндэсний тусгаар тогтнолоо тунхагласан явдалтай холбогдуулан “Үндэсний эрх чөлөөний хувьсгал” хэмээх хувьсгалын нэгэн хэв маягийг дорнод европын судлаачид хөрөнгөтний хувьсгалын хэв маягийн сонгодог ангилал дээр нэмэн, нийгмийн шинжлэх ухаанд гаргаж ирсэн билээ.

Ингээд Ар Монголд өрнөсөн Үндэсний эрх чөлөөний хувьсгалын эн тэргүүний зорилт бол харийн ноёрхлыг устгаж, үндэсний тусгаар тогтнолоо бүрэн олох явдал байлаа. Хувьсгалын дараагийн зорилт бол үндэсний нэгдлээ сэргээж нэгдсэн Монгол улсаа байгуулах явдал байв. Бүр өмнө Халхын Хүрээний Бүх Хэргийг Түр Ерөнхийлөн Шийтгэх Газар Монголын тусгаар тогтнолыг сэргээх бэлтгэл ажлаа шуурхайлан явуулахдаа зөвхөн Ар Монголоор хязгаарлахгүй, харин Чин улсын ноёрхол дахь олон монголчуудаа тусгаар тогтнолын төлөө тэмцэлд босгохыг заасан Жэбзундамба хутагтын лүндэнг өөрийн хөтөлбөр болгож байсныг бид өмнө өгүүлсэн билээ. Иймээс Монгол улсын Засгийн газар 12 сарын 7-нд Шилийн гол, Улаанцав, Их Зуугийн чуулганы дарга нар, Алашаагийн ван, Дарьганга, шинэ хуучин Баргын олон хошууны бүгдийн дарга нарт албан бичиг явуулж, өөрсдийн нутгийн сүв боомт газруудад цэрэг яаралтай томилон суулгаж дайсан этгээдийг янагш нэвтрүүлэхгүй байх, хэрэв зөрчигчид байвал үлдэн зайлуулж, Хүрээнд яаралтай мэдэгдэхийг тушаасан байна.

Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгал нь Чин улсын захиргаанд байгаа бүх нутгаа чөлөөлж, Ар монголоор төвлөсөн үндэсний нэгдсэн улсаа байгуулах чиглэлээр гүнзгийрч байлаа. Иймд, давын өмнө биелүүлэх зорилго бол Ар, Өвөр ба Барга, Дарьганга, Хөх нуур, Алашаа, Ил Тарвагатайн монголчуудын бүх нутгийг хяналтандаа оруулах, тэгэхдээ хятадын өмнөд нутагт тулгар тогтсон Бүгд Найрамдах Засгийн газар ба бусад олон улсаар тусгаар тогтнолоо хүлээлгэн зөвшөөрүүлэх явдал байлаа. Чин улсын Ар Монгол дахь захиргааны чухал төв-Улиастай, Ховдыг аль болох түргэн хугацаанд чөлөөлөх нь үндэсний эрх чөлөөний хувьсгалын цаашдын гүнзгийрэлтэд гарцаагүй нөлөөлөх зүйл байв. Иймээс Хүрээнд Монголын тусгаар тогтнолыг тунхаглахаас өмнө ХХБХТЕШГ баруун аймгуудын чуулганд орон нутгаас цэрэг дайчилж, уг газруудыг даруй чөлөөлөхийг тушаасан билээ. Тэр ёсоор баруун аймгийн чуулган хошууд харьяат нутгаасаа дайчилсан цэргийн хүчээр Улиастай хотыг чөлөөлөхөөр очиход, манж жанжин, сайд нар нь гаднаас туслах хүчин авах найдваргүй байсан учраас 1912 оны 1 сарын 21-нд эсэргүүцэлгүй бууж өгснөөр Улиастай хот чөлөөлөгдсөн юм.

Ховдын Манж сайдын захиргаа Улиастайн адил бууж өгөөгүй, харин орон нутгаас хүрэлцэн очсон чөлөөлөх цэргийг эсэргүүцэн тулалдахаар шууд бэлтгэж

эхэлсэн тул Монгол улсын Засгийн газар нийслэл Хүрээнээс ГЯЯ-ны дэд сайд Дамдинсүрэн, гүн Магсаржав нараар цэрэг удирдуулан 1912 оны зуны эхэн сарын шинэдээр хөдөлгөхийн зэрэгцээгээр баруун хоёр аймгаас цэрэг нэмж дайчлан хөдөлгөх шийдвэр гаргаж, нутгийн хүн амд тусгаар тогтнолын учир холбогдлыг тайлбарлан таниулах ажлыг янз бүрийн арга хэлбэрээр өргөн зохиов.

Олноо өргөгдсөний хоёрдугаар /1912/ оны 7-р сард сайн ноён хан Намнансүрэнг шинэ байгуулагдаж байгаа Ерөнхийлөн Захирах Яамны сайд буюу ерөнхий сайдаар томилуулжээ. Тэр үед яаралтай цэрэг бэлтгэж, орчин үеийн буу зэвсэг эзэмшүүлэх шаардлагатай байсан тул Намнансүрэн энэ ажилд шуурхайлан орж Орос улсаас цэргийн сургагч урьж, морьт цэрэг сурган боловсруулах ажлыг яаралтай зохиов. Манж, хятадын этгээдүүд Монгол дахь Чин улсын захиргааны сүүлчийн үүр болсон Ховдын хязгаарыг Монгол улсын захиргаанд оруулахгүй байхын тулд Бээжинд Монгол Төвдийн хэрэг эрхлэх товчоонд алба хааж байсан Палта ванг Алтайн хязгаарын захирагчаар томилж, баруун Монгол ноёд хийгээд ард олон Ар Монголтой хамтрахыг хориглох явуулга хийлгэх болов. Түүгээр дамжуулан Дөрвөдийн Далай хан Галсаннамжилыг Халхыг бүү дага! хэмээн ятгуулж явуулжээ.

Мөн ДИУ-ын шинэ ерөнхийлөгч Юан-Шикай засгийн газрынхаа хуралдаанд “Баруун Монгол” гэсэн засаг захиргааны шинэ нэгж байгуулах тухай төслийг оруулан хэлэлцүүлж, тэрхүү засаг захиргааны шинэ нэгжид Ховд, Алтайн хязгаар, Урианхайн хязгаар, Алашаа, Хөх нуур, Эзэн голын торгуудын нутаг дэвсгэрийг хамаруулжээ. Гэвч Бээжингийн энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Ховд болон Алтайн хязгаар дахь хувьсгалт үйл явцын өрнөлт саад болсон ажээ. Энэ бүс нутагт манж нарыг хөөн зайлуулж, шинэ тулгар тогтсон Олноо Өргөгдсөн Монгол Улсаа дагах хүсэлтэй баядын гүн Түмэнбаяр, Дөрвөдийн зоригт ван Содномжамцой, залуу Далай хан Түмэндэлгэржав, хасаг ноёд Хлан, Бодубай нар байв.

Хязгаарын ноёдын дунд хятадын харьяанд орох хүсэлтэй хүмүүс болох дөрвөдийн хан Галсаннамжил, баядын ноён Нацаг бэйс, хасгийн ноён Сукирбай нар ч байв. Ийнхүү хязгаарын гадаад, дотоод байдал нэн түгшүүртэй байсан үед Монгол улсын Цэргийн яамнаас 1911 оны 12 сарын 30-нд Баруун хязгаарыг сэргийлэн тохинуулах сайдаар бэйс Гончигдамбыг томилжээ. Бэйсийн үйл ажиллагаа хангалтгүй байна хэмээн Монгол улсын Засгийн газар үзээд 1912 оны 3 сар Жалханз хутагт Дамдинбазарыг баруун хязгаарыг илбэн тохинуулах сайдаар, гүн Хайсанг зөвлөн туслах сайдаар, мөн 6 сард Р.Наваанцэрэнг баруун хязгаарыг сэргийлэн батлах сайдаар тус тус томилжээ. Түүнчлэн Цэргийн яамнаас баргын гүн Ж.Дамдинсүрэн, гүн С. Магсаржав нарыг хамтаар баруун хязгаарыг түвшитгэн тогтоох сайдын тушаалд тохоон тавьж, хязгаарын цэргийг захируулахаар томилсон байна. Тэд богино хугацаанд олон талтай арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн юм. Ингээд 1912 оны 4, 7-р сарын хооронд Дөрвөд 16 хошуу Хүрээний Засгийн газарт харьяалагдах хүслээ илэрхийлж албан бичиг ирүүлснээс гадна баруун хязгаараас Захчин 2 хошуу, Алтай Урианхайн 7 хошуу,

Торгуудын 3 хошуу, Өөлэд, Мянгадын тус бүр нэг хошуу мөн хасаг зэрэг бусад ястнууд удаа дараалан дагаар ирж Олноо Өргөгдсөн Монгол Улсын харьяат болсон билээ.

Манлай баатар Дамдинсүрэн

1912 оны эхээр зэвсэглэсэн ардуудаа Улаангом болон түүний ойр газарт байсан хятад худалдаачдыг дайрч цохиход цөөн зарим нь Ховд руу зугтсан байв. Ингэж Ховд хот Монгол улсын эсрэг хүчний үүр болж бүхийд Хүрээнээс, Баргаас дагаар ирж Гадаад Яамны дэд сайдаар томилогдон гүнгийн зэрэг шагнагдсан занги Дамдинсүрэн, Сайн ноён хан аймгаас Ховдын халх жасаанд сууж байгаад, тэнд бий болсон түгшүүрт байдлыг мэдээлэхээр ирж, Дотоод Яамны дэс түшмэл болон дэвшсэн гүн Магсаржав нар цэрэг удирдаж мордоход Горлосын Тогтох тайжийн цэрэг бас оролцож явав. Магсаржав, Дамдинсүрэн нар Ховдыг чөлөөлөхийн төлөө тулалдаанаа анх эхэлж бүслээд, Синьцзяны зүгээс Ховдод туслахаар ирсэн цэрэг ба хотын дотроос ихээхэн эсэргүүцэлтэй даруй 3 сар тулалдаж байв. VIII сарын 7-ны шөнө нийт монгол цэргийн хүчээр Ховд хотод 4 зүгээс нь дайран орсон. Ингээд 1912 оны 8 сарын 7-нд Дамдинсүрэн, Магсаржав, орон нутгаас Жаханз хутагт Дамдинбазар, болон Дамбийжанцангаар удирдуулсан таван мянган цэрэг бүхий арми Ховд хотыг эзлэн авсанаар баруун хязгаар манжийн эрхшээлээс гарсан юм. Энэ үйл явдал нь бусад монголчуудад зоригжуулагч жишээ болж, монгол туургатан нэгдэж, үндэсний төр улсаа бататгах чин зоригийг улам бадраасан ажээ.

Ховдод байсан манжийн түшмэдүүд болон цэргүүд болох 699 хүн оросын консулын газар орогнож байгаад 9 дүгээр сарын эхээр Кош-Агач, Бийск, Эрхүүгээр дамжин хятад руу буцжээ. Ховдыг чөлөөлөх үед оросын консул Кузьминский чухал мэдээ нэвтрүүлэхэд туслан багагүй үүрэг гүйцэтгэсэн тул Богд хааны зарлигаар улсад туслагч гүнгийн зэрэг, жинс, тогосын отго шагнажээ.

Ховдыг эзлэн авсны дараа Монгол Улсын Засгийн газар Алтайн хязгаарын захирагч Палтыг Шара сүмийг чөлөөлөхийг шаардсан боловч тэрбээр хүлээн авсангүй. Хятадууд Баруун хязгаарт өөрсдийн нөлөөнд эргүүлэн авахыг оролдож байлаа. Энэ байдалд Оросын тал Монголд нилээд дэмжлэг үзүүлсэн амуй. Есдүгээр сарын 4-нд Оросын Гадаад хэргийн яамны сайд Сазонов Цэргийн яамны сайд Сухомлиновт: "монголчууд Ховдыг эзлэн авлаа. Энэ нь Баруун Монгол дахь байдлыг нэлээд өөрчиллөө. Хойшид хятадуудын довтолгооныг няцаахын тулд цэрэг илгээ, монголчуудыг зэвсэгээр хангая" гэсэн санал дэвшүүлжээ. Ингээд Эрхүүгийн цэргийн тойрогт 300 казак цэрэг, пулемёт их буу зэргийг байлдааны бэлэн байдалд оруулан, шаардлагатай үед Монголруу илгэхээр бэлджээ. Мөн Монголын засгийн газарт 6 мянган винтов, 3 сая патрон, 2 мянган сэлэм, 2 ачиж явдаг хөлтэй суурин маягийн хүнд пулемёт ба 2 хөнгөн их буу зарах асуудлыг нааштай шийдвэрлэжээ. Баруун хязгаар дахь дайн байлдаан болон үймээн самууны үеэр торгуудуудын зарим хэсэг Шиньжан руу зугтаж, урианхайчууд тэмцэлд босон, 4 мянга орчим казакууд Горный Алтай руу

зугтан Николай хаанаас харьяат албат нь болохыг хүсч байлаа. 1912 оны намар 1913 оны өвөл Палтын цэрэг байнга Ховд руу довтолж баруун хязгаарын байдал маш түгшүүртэй байсан энэ үед хятадууд тийшээ цэргээ татаж, тэдний цэргийн тоо нь 3000 хүрч байв. Бээжингийн хувьд тус бүс нутаг нь баруун зүгээр Монгол руу орох гарц бөгөөд Хаант Оростой хиллэх газарт аюулгүй байдлаа хангах чухал орон зай болж байлаа. Харин Хаант Орос нь Алтайн хязгаар бол газар зүй, угсаатны хувьд Семипалатинскийн үргэлжлэл хэмээн үзэж, улмаар Баруун Монгол, Шиньжаан руу худалдаа-эдийн засгийн хувьд нэвтрэх чухал газар нь болж байжээ. Баруун хязгаар нь монгол овогтны өлгий нутгийн нэг, түүний салшгүй нэгэн хэсэг болохын хувьд Монгол Улсын Засгийн газрын анхаарлын гол төвд байсан юм. Тиймээс Баруун хязгаар нь Монгол, Орос, Хятадын өрсөлдөөний талбар болж байлаа. Нөгөө талаар Орос-Монголын хооронд 1912 оны намар байгуулагдсан гэрээний нэгдүгээр зүйлд заасан: "Оросын Эзэн хааны Засгийн газраас Монгол улсад өөртөө засан тогтнож, өөрөө эзэрхэх ёс журам, өөрийн нутаг Хятадын цэрэг болон нүүдлийн иргэдийг оруулахгүй, өөрийн үндэсний цэрэг байгуулах эрхийг эдлэхэд тусална" гэсэн заалт нь дээрхи бүс нутгийн асуудалд Хаант Орос оролцох эрх зүйн үндэс нь болж байлаа. Хятадын тал Орос-Монголын гэрээг огт хүлээн зөвшөөрөхгүй "Монгол бол манай нэг хэсэг" гээд улмаар дараа нь хятадын оролцоогүй Монголын асуудлыг хэлэлцэх бололцоогүй хэмээн мэдэгдэж байлаа.

Өгүүлэн буй үед Монголын Засгийн газрын Улиастай дахь төлөөлөгч ноён Гомбоцэдэн Оросын Засгийн газарт хандан зэр зэвсгийн тусламж хүсч байгаагаа консул А.Вальтерээр дамжуулан хүсэлт тавьхад, тэрээр Гадаад яамандаа хүсэлтийг хүлээн авах нь зүйтэй хэмээн зөвлөжээ. Консул Монголын цэргүүдийн хамт дэд есаул Харановоор удирдуулсан казак цэргийн ангийг тулалдаанд оруулж, тэд ялалт байгуулсан байна. Оросын консул А.Успенский Палт ванг дайны ажиллагаагаа зогсоохыг шаардаж байв. Улмаар Оросын засгийн газар хятадууд Шиньжаанаас Ховд руу цэрэг илгээж байгаа явдлыг зогсоохгүй бол Монголын талаарх хэлэлцээр хийх боломжгүй гэдгээ мэдэгдэж байв. Харин Ховд дахь Магсаржав тэргүүтэй монголын тал Цагаан түнх дахь хятадын цэргийн хүчий эсрэг довтолгоон хийх зориг төгөлдөр байлаа. Монгол улс болон Хятадын хувьд стратегийн асар их ач холбогдолтой Цагаан түнхийн төлөө хэд хэдэн ширүүн тулалдаан болсон бөгөөд 1913 оны өвөл Оросын Засгийн газар Дээд Үдийн хорооны анги нэгтгэлүүдээс Ховд руу илгээж, мөн зун нь Бийскээс явган цэрэг, их буу татаж монголчуудын дайны ажиллагаанд ихээхэн дэмжлэг үзүүлсэн байна. Энэ үйл явдлын гэрч болсон А.В.Бурдуков оросын цэргүүд ирсэн явдал нь хятад цэргүүдийн үйл ажиллагааг хөдөлгөөнгүй болгож, тэд Цагаан түнхээс нааш хөдлөлгүй, киргизуудыг монголчуудын эсрэг ашиглахыг оролдож байсан боловч тэдгээрийг нь монгол цэргүүд хялбархан бут ниргэж, тэдний байлдах хүсэлгүй болгож байлаа хэмээн бичсэн байдаг.

Тэр үед Халхын өмнөд хошуунд, тухайлбал Чин улсын суман өртөөний чухал зангилаа Сайр уснаас манж, хятад албаны хүмүүс болон Хятад худалдаачдыг үлдэн зайлуулах тэмцэл 1912 оны эхээр эрчимтэй явагдаж

байлаа. Дарьганга дахь Манжийн хааны сүргийн бүгдийн тэргүүн Содномдовдон, гарын тэргүүн Магсаржав нар Олноо Өргөгдсөн Монгол Улсад дагаар орж захирагдахаа 1912 оны 3 сарын 3-нд албан бичгээр мэдэгдээд шинэ тулгар Монгол Улсдаа нэгдсэн.

Ар Монголын нутгийг Манж-Хятадын захиргаанаас шуурхай чөлөөлж байсан нь бусад монголчуудад зоригжуулах жишээ болж байлаа. Их Хүрээнд монголын тусгаар тогтнолыг тунхаглан, Өвөр монголын засаг хошуудад яаравчлан мэдэгдсэн явдал Өвөр Монгол дахь үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгчдийг ихэд зоригжуулав. Тэр үед Харчины засаг ноён, жүн ван Гүнсэnnоровын хошуу нь Бээжинд ойр байснаас гадна Манжийн хаан угсааныхантай ураг төрлийн холбоотой байсан тул Гүнсэnnоров Чин улсын хаант төрийг илэрхий эсэргүүцэж зүрхлэхгүй байсан ажээ. Харин Манжийн эзэн хаан ширээнээс буусныг зарламагц тэр 1912 оны эхээр Улаан хадад очиж, Зост, Зуу-Уд хоёр чуулганы ноёдыг цуглуулан Өвөрмонголыг цаашид хэрхэх асуудлыг зөвлөн хэлэлцсэн байна. Түүнээс гадна Жэбзүндамба хутагтыг Монгол улсын хаан ширээнд өргөмжлөх ёслолд оролцуулах төлөөлөгчөөр Лувсан-Чэжүүр гэгч хүнийг томилж, Ар, Өвөр монголыг хамтатгах арга замыг сүвэгчлэн тохиролцуулахаар явуулсанд Богд Жэбзүндамба хутагт хаан түүний төлөөлөгчийг талархан хүлээн авч Гүнсэnnоровыг Өвөр 49 хошууг удирдан захирч, хувьсгал хийлгэхээр томилсон гэж Тайваньд хэвлүүлсэн зохиолдоо түүхч Сачисэцэн /Захчид Сэцэн/ бичсэн байна. Энэхүү мэдээллийг нотлох баримт бидэнд хараахан олдоогүй байгаа. Ямар ч атугай Өвөр Монгол Манж, хятадын ноёрхлыг эсэргүүцсэн энд тэндгүй гарч байсан нь Хятад дахь Чингийн ноёрхол унаж байгаа байдал мөн хятадын цагаагчин гахай жилийн хувьсгал өрнөж байсантай ямар нэгэн байдлаар холбоотой ч гэсэн гарал угсаа нэгтэй Ар Монголд амжилттай өрнөж байгаа тэмцлийн хувьсгалжуулах нөлөө асар их байсныг илтгэнэ. Хэдүй тийм боловч Өвөр Монголд Ар Монголыг биш харин Хятадыг дагах нь ашигтай хэмээн үзэж байсан хэсэг байсан бөгөөд тэд Өвөр Монголын шашны тэргүүн Жанжаа хутагт, Хөх хотын тэргүүн дээд лам нар ухуулан бичиг орон нутагтаа болон Нийслэл Хүрээнд байсан өвөр монгол хүмүүст илгээж байжээ.

Нөгөө талаар 1912 оны 2 дугаар сарын 12-нд Манж Дайчин улсын төр мөхөж түүний ор суурийг залгамжилсан ДИУ-ын эрх баригчид дэлхийн хүчирхэг гүрэн байгуулахын тулд Манжийн эрхшээлд байсан үндэстэн ястнуудыг нэгтгэсэн их улс байгуулах бодлого тунхагласан юм. Монгол улсын эзэн хаан Богд Жэбзүндамба тэргүүтэй Ар Монголын эрх баригчид хятадын элдэв ов мэхэнд автаж бусдын эрхшээлд дахин орохгүйн тулд бүх монгол үндэстэн нэгдэн нийлж Нармай (Их-Ж.У) Улс байгуулах тухайгаа ухуулан тунхаглаж байсан бөгөөд үүнийг нь нийт монголчууд талархан дэмжиж байлаа.

Ингээд 1911 оны эцэс 1912 оны эхээр Өвөр Монголын ихэс дээдсийн олонх нь Олноо өргөгдсөн Монгол Улсдаа дагаар орохоо мэдэгдэх болов. Ар Монголтой залгаа оршдог Хөлөнбуйрт үндэсний эрх чөлөөний Өвөр монголын аль ч хошуу нутгаас илүү хүчтэй өрнөсөн юм. Хөлөнбуйрын Өөлд бүгдийн дарга

Шэн Фу тэргүүтэй ноёд 1912 оны эхээр хуралдаж, Их Хүрээнд байгуулсан Монгол Улсын Засгийн газрыг зөвшөөрөн хүлээж дагахаа илэрхийлсэн төлөөлөгчөөр Солон хошууны бүгдийн дарга Цэндийг явуулахаар тогтсон ажээ. Үүнээс гадна Баргын үндэсний эрх чөлөөний хөдлгөөний зарим удирдагч, тухайлбал: сумын занги Дамдинсүрэн, бичээч Гайхасу нарын 7 хүн, Баргыг төлөөлөн Нийслэл Хүрээнд хүрэлцэн ирэв. Богд хаан Баргын хүсэлтийг ёсоор болгож, шинэ Баргын Шулуун цагаан хошууны гутгаар сумын занги Дамдинсүрэн /1871-1921/-д улсад туслагч гүнгийн зэрэг, бусад дагалдан ирсэн зэрэгтэй, зэрэггүй хүмүүст 5-р зэргээс дэд зэрэг хүртэл жинс зэрэг шагнаснаас гадна мөнхүү гүн Дамдинсүрэнг Гадаад яамны дэд сайдаар тохоон томилжээ.

Хөлөнбуйр бүхэлдээ монгол улсын захиргаанд багтах болж бүхий л хэрэг явдлыг Олноо Өргөгдсөн Монгол Улсын төрийн зааврын дагуу хөтлөн явуулдаг болов. Монголын Засгийн газар Хөлөнбуйрын тусгаар тогтнолын хөдөлгөөнийг тэргүүлсэн шинэ Баргын бүгдийн дарга Шинфү ноёныг дэвшүүлэн, Хөлөнбуйрыг ерөнхийлөн захирах сайдаар томилж, тамга шийтгэн олгожээ.

Ар Монгол ба Хөлөнбуйрт гарсан тусгаар тогтнолын тэмцлийг дэмжсэн Шилийн голын чуулганд өрнөв. Түүнийг чуулганы дарга жүн ван Лхаваанноров тэргүүлж, тус чуулганы 6 хошуу Монголын Засгийн газрыг зөвшөөрөн хүлээж, дагахаа илэрхийлсэн ажээ. Хөлөнбуйрын монголчууд Олноо Өргөгдсөн Монгол Улсын засгийн газрыг зөвшөөрөн хүлээж, түүнтэй нэгдэж, тусгаар улс болохоо зарласан нь Баруун ба Өвөр монголын бусад хошуудад үлгэр дууриалал болов.

1910 оны 11 сарын 19-нд шинэ хязгаар /синьцзян/-ын Илийн газарт байсан Хятад цэргүүд үймээн гаргаж, тэнд суугаа жанжныг алаад тус нутаг орны оршин суугчдыг өөрсөддөө хүчээр дагуулахыг оролдсон ажээ. Тэгэхэд Чахар зүүн гарын 8 хошуу тэднийг дагахаас татгалзсан тул хятад цэрэгтэй нэг сар гаруй тулалдаад, эцэст нь хүчин мөхөсдөж, Хөвөөт Шар хошууны дэд дарга Сумъяагийн удирдлагаар 116 өрхийн 512 хүн Орос улсын нутаг руу ойж гараад, улмаар 1912 оны 7 сард Олноо Өргөгдсөн Монгол Улсад 58 өрхийн 271 хүн нь мөнхүү Сумъяагийн удирдлагаар орж ирсэн. Хятад цэргүүд нутагтаа үлдсэн Чахар ард олныг харгислан дарж, мал агуурсыг нь залилан аваад амь тэжээхэд маш хэцүү болгосон ажээ.

Дотоод монголын 49 хошууны 38 хошуу нь Олноо Өргөгдсөн Монгол Улстай нэгдэж нэгэн улс болох саналаа илэрхийлэн албан бичиг баримт гаргаж өөрсдийн төлөөлөгчдөө Их Хүрээнд ирүүлсэн ажээ. Монгол Улсын хаан ийнхүү дотоод монголын олон хошууд чуулганы хошуу дагаар орохоо илэрхийлснийг талархан хүлээн авч эл хэрэгт хүчин зүтгэж гавьяа байгуулсан хүмүүст Чин улсын үеийн ноёдын зэрэг дэвий нь шат ахиулан харьяат чуулган хошуугаа захирах тамга, захирлага шийтгэн олгож, хөхүүлэхийн зэрэгцээгээр бичиг цэргийн чадвартай зарим ноёд түшмэдийг Монгол улсын ерөнхийлөн захирах яам болон төрийн бусад яаманд дэвшүүлэн ажиллуулав. Үүнд: Олноо Өргөгдсөн Монгол Улсын ерөнхий сайдын орлогчоор Жирмийн чуулганы Хорчин зүүн гарын өмнөд хошууны засаг жүн ван Гончигсүрэн, Дотоод яамны дэд сайдаар Зостын чуулганы Харчин вангийн хошууны захирагч занги Хайсан, Гадаад яамны дэд

сайдаар Баргын Дамдинсүрэн, Баргын гүн Цэнд, Цэргийн яамны дэд сайдаар Жиримийн чуулганы бишрэлт бэйс Пунцагравдан, тайж Тогтох нарыг урд хожид тус тус томилон ажиллуулсан байна .

Ингээд монголчуудын үндэсний нэгдмэл улсаа байгуулах гэсэн тэрхүү үйл явц тэмцэл нь 1915 оны сүүлчийн хагас хүртэл үргэлжилсэн юм. ДИУ, урьдын Чин улсын ноёрхлыг өвлөж, түүний захиргаанд байсан Монгол орныг эзэгнэх бодлого явуулсан билээ. Тэр нь монголчуудын зүй ёсны эсэргүүцэлтэй тулгарч байв. Хятадтай зэргэлдээ оршдог Өвөр Монголд тийм эсэргүүцэл олон гарч байсны заримыг дурдвал: Жиримийн чуулганы Хорчин баруун гарын хойд хошууны засаг Раашминжүүр нар 1912 оны хавраас ДИУ-ын ноёрхлын эсрэг бослого гаргахаар бэлтгэж эхэлжээ. Тэгээд 4-р сард Удай Ар Монгол руу тусгай элч илгээж, Жэбзундамбад бараалхуулан Жирмийн чуулганы арван хошуутай нэгдэж бослого гаргах учраа илтгэн туслахыг гуйжээ .

Их Хүрээ тэднийг дэмжсэн тул “Зүүн Монголын тусгаар тогтнолын тунхаг”-ийг гаргаж, 1913 оны 8 сарын 20-нд тусгаар тогтнолоо зарлан Шаазгай хот болон Чжэньдун, Цзиньан хоёр сянийг эзлэн авч, Хятадын засаг захиргааны бүх хүмүүсийг Монгол аймгуудын нутгаас зайлахыг шаарджээ. Юань Шикайн засгийн газар Өвөр Монгол даяар өрнөж буй ДИУ-ыг эсэргүүцэж Монгол улстайгаа нэгдэх гэсэн хийгээд Удайгийн удирдсан ард түмний бослогын тухай мэдээг сонсмогц даруй зүүн гурван муж болон Халуун голоос цэрэг хөдөлгөн Шаазгай хот ба Чжэньдунгийн хавьд ширүүн тулалдаж Кайлу хотыг эзлэн авч босогчдыг цэргийн хүчээр дарсан ажээ. Мөн оны 9-р сарын 12-нд Удай, Раашминжүүр нар үлдэгдэл хүч хэдэн арван морьтноо дагуулан Солон ууланд зугатаж гарсан. Тэгээд Удай нь Хөлөнг дайран Их Хүрээ рүү, Раашминжүүр нь Үзэмчний нутгаар тус тус Ар Монгол руу ойж гарсан амуй. Удай вангийн удирдлагаар гарсан зэвсэгт бослого бүрэн дарагдсан ажээ.

1912 оны 11-р сард Их хүрээнд хүрэлцэн ирсэн Удай вангийн албат, иргэд, гэр бүлийг Олноо Өргөгдсөн Монгол Улсын засгийн газар тохинуулан суулгахын хамт Удайг Цэргийн Яамны дэд сайдаар томилон ажиллуулав. Мөнхүү бослогын бас нэг удирдагч бэйс Раашминжүүр үлдэгдэл хүчээ дагуулан, Их хүрээнд ирснийг Олноо Өргөгдсөн Монгол Улс талархан хүлээн авч тохинуулан суулгаад түүнийг Гадаад Явдлын Яамны дэд сайдаар томилон ажиллуулсан билээ.

Удай ван

Өвөр Монголоос дүрвэж ирсэн хүмүүст Ар Монголын хойд хил дагуух хуучин харуулуудын харьяанд байсан нутгаас олгож, тэднийг тохинуулан аж төрүүлэх талаар Олноо Өргөгдсөн Монгол Улсын засгийн газар их анхаарч байв. ДИУ-ын засгийн газар, Өвөр Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дарахын тулд 1912 оны зун үлэмжхэн цэргийг Чуулалт хаалга, Бат хаалга, Долон нуур, Хөх хот, Бугат хотын чиглэлд таван замаар анги хуваан түлхэн оруулав. Хятадын цэрэг орсон газар бүхнээ түйвээж байгаа гашуун зовлонг

Өвөр монголчууд Монгол Улсын засгийн газарт мэдэгдэж, Хятадын харгис цэргийн эрхтнээс чөлөөлж авахыг гуйсан айлтгал, өргөдөл өдий төдийг ирүүлэх болжээ. Зарим нь шууд цэрэг зэвсгийн хүчээр нутгаа чөлөөлж нэгтгэхийг гуйж байлаа. Монгол Улсын Цэргийн Хэргийг Бүгд Захиран Шийтгэх Яамнаас Олноо Өргөгдсөний 2-р оны өвлийн сүүл сарын 18 /1913 оны 1-р сарын 25/-нд хаанд өргөсөн айлтгалдаа: "...газар орныг хамгаалан сэргийлэл бэлтгэх баатар мэргэн цэрэг, хурц зэвсэг олгуулахыг эрж бичиг захидал хүргэж ирсэн "гэж Өвөр Монголчууд тусламж гуйж байгааг дурдаад: "...энэ завсар Хятад цэрэг улмаар янагш давшин хандаж буй тул зүй нь бүхий олон газрын түшмэл цэргийг бүгд таван зам хуваан мордуулбаас зохих учрыг илтгэн таван чиглэлд хэн хэний удирдлагаар цэрэг хөдөлгөх саналаа төлөвлөн тавьж зарлигаар батлуулсан. Үүнд:

Нэгдүгээр зам нь: Егүзэрийн хийдийн чиглэлд бэйсийн зэрэг туслагч Чимэдцэрэнгийн удирдсан цэрэг

Хоёрдугаар зам нь: Дарьгангын чиглэлд Дэс түшмэл чин зүтгэлт гүн Хайсан, дэд сайд Бавуужав нарын цэрэг

Гуравдугаар зам нь: Сөнидийн хоёр хошуу, дөрвөд вангийн чиглэлд дэд сайд, бишрэлт бэйс Насан-арвижихын цэрэг

Дөрөвдүгээр зам нь: Хөх хотын чиглэлд, сайд гүн Сономдоржийн цэрэг

Тавдугаар зам нь: Урадын гурван гүн, Хатан голын чиглэлд, дэд зэрэг түшмэл Зүтгэлтийн цэрэг тус тус хөдлөх болсон ажээ. Мөн Ховдын хязгаарыг чөлөөлөх дайнд гавьяа байгуулж үе улиран залгамжлах засаг, бэйл, цэргийн жанжин, манлай баатар цолоор шагнуулсан баргын Дамдинсүрэнг зүүн өмнө зүгийн цэргийг дайчлан захирах жанжнаар тохоон томилжээ.

Монгол улсын Засгийн газар ийнхүү зэр зэвсгийн хүчээр Өвөр Монголыг өмгөөлөх цэрэг томилон гаргахын зэрэгцээгээр өөрийн засгийн газрын нэрийн өмнөөс ухуулга суртал нэвтрүүлэг хийж дагаар ирсэн ба ирээгүй монгол овогтонд зориулан ухуулан зарлах бичиг тарааж байлаа. 1913 оны 1-р сард Өвөр Монгол руу хөдөлсөн нэг түмэн цэрэгт Хүрээний цэргийн сургууль ба Халхын аймаг хошуудаас татсан цэрэг оролцсон юм. Мөн зам зуураасаа болон хүрсэн газраасаа цэрэг нэмэн элсүүлэх ёстой байв. Харин цэргийн захирагчаар томилогдсон хүмүүс нь голдуу Өвөр Монголоос дагаар ирээд нутаг орноо чөлөөлөхийг эрмэлзсэн хүмүүс байлаа. Тэд газар орны байдлыг сайн мэддэгийн хувьд цэрэг толгойлж явахад нэн тохиромжтой байв. Засгийн газар Өвөр Монгол руу хөдөлж байгаа цэрэгтээ: "...Харьяат түшмэд цэргүүд хүрсэн эл газарт номхон шударгаар амьдрах аливаа ардыг өчүүхэн төдий халдан дарлаж, гаслаган зовоохгүй бүгдээр үнэн санаагаар хүчлэн зүтгэж, чухам тус зүйн хэргийг хичээн, ёс журам, цэвэр ичимтгийг сахин явж гавьяаг илэрхийлбээс зохино "гэж тушааснаас үзэхэд энэхүү таван замын цэрэг бол Хятадын түрэмгийллээс Өвөр Монголын нутаг орныг өмгөөлөн хамгаалах зорилготой байсан нь илэрхий байна. Монгол улсын цэрэг хэдий гээр тоогоор цөөн боловч баатарлаг зоригтой тулалдаж, Өвөр Монголын нутаг орныг чөлөөлж байлаа. Нутгийн Монгол ард иргэд, Монгол улсын хааны цэргийг газар бүр дэмжиж хоол хүнс, уналгаар

дэмжиж, өөрсдөө тэдний эгнээнд элсэн орж байлаа. 1913 оны зун Өвөр Монголын нутагт байлдаж явсан монгол цэрэг Хятадын үлэмжхэн цэрэгтэй олон газар шаргуу тулалдаан хийж байжээ. Мөн тэр үед Ховд, Алтайн хязгаарын зааг Цагаан Түнхэний Улаанхайрхан гэдэг газар Монгол, Хятад цэргийн хооронд ширүүн тулалдаан болж байв. 1913 оны намар Шилийн гол, Чахарын нутаг чөлөөлөгдөж дууссан бөгөөд улмаар Монгол цэрэг Цагаан хэрэмд зарим газраар тулж очоод ялангуяа Чуулалт хаалга хотын хэрмийн хаалганы араас эхлэн Монгол нутгийн хилийг хамгаалж байжээ.

Монгол хошуу нутаг дагаар ирэх явдал Олноо Өргөгдсөн Монгол Улсын цэрэг, Өвөр Монголын нутагт чөлөөлөхөөр орсноос хойш улам ихэссэн. Иймд Монгол улсын Засгийн газар, дагаар орсон хязгаар нутгийн хэргийг захиран шийтгэх тусгай сайдын газрууд байгуулсан. Тэгэхэд зүүн хязгаар бол чухал газрын нэг болж байсан тул Олноо Өргөгдсөний 3-р оны 6 сарын 30 (1913 оны 8 сарын 1)-нд Богд хааны зарлигаар Егүзэр хутагт Галсандашийг Зүүн хязгаарын хэргийг захиран шийтгэх сайдаар томилсон юм.

Үүний зэрэгцээгээр Монгол улсын засгийн газар Өвөр монголтой түргэн шуурхай харилцан алба нэвтрүүлж байхын тулд нийслэл Хүрээнээс зүүн тийш одоогийн Дорнод аймгийн нутаг Бадам-Ишээс Солон баргын зүг, мөн Шаваржаргалантаас зам салж, Шилийн голын чуулганы нутагт хүртэл, өмнө зүг одоогийн Дорноговь аймгийн Сулинхээр сумын нутаг Ар Дэрс гэдэг газраас урагш залгаж, өвөр чуулгадын нутгаар олон салаа морин өртөө байгуулсан амуй. Өвөр Монголыг өмгөөлөх дайны ажиллагаа энэ мэтээр явагдаж байхад ДИУ-ын Засгийн газар Орос дахь өөрийн элчингээр дамжуулан, Өвөр Монгол дахь дайны ажиллагааг зогсоолгох талаар Монголын засгийн газарт шаардаж өгөхийг Оросын ГЯЯ-нд хүсчээ. Бас Бээжин дэх Оросын элчинд мөнхүү хүсэлтээ тавьсан байна. Оросын ГЯЯ Хүрээ, Бээжин дэх өөрийн төлөөлөгчөөр дамжуулан, Өвөр Монгол дахь дайны ажиллагааг зогсоох шаардлагыг Монгол, ДИУ-ын талд тавьж байв.

Монгол Улсын Засгийн газрыг нэгэнт зөвшөөрөн хүлээж дагаар орсон Хөлөнбуйр, Өвөр Монголын хошууд, өөрсдийн харьяат нутгийн худалдаа арилжаанаас хураасан гаалийн орлогоос засгийн газарт 1912 оноос эхлэн тушаах болсон нь Өвөр Монголын нутгийг Хятадаас чөлөөлөхөөр хөдөлсөн цэргийн зардал сүйтгэлд бага ч атугай нөхвөр болж байв. Ар, Өвөр Монголын аль нь ч гэсэн он удаан жил Чин улсын хоцрогдмол хязгаар нутаг болж байсан агаад үндэсний худалдаа зах зээл, үйлдвэр хөгжөөгүй байсан тул үндэсний улс төрөө сэргээж, нутаг орноо чөлөөлөхийн төлөө тэмцсэн энэ гурван жил орчмын хугацаанд юм, юмаар ихэд дутагдаж, ард түмний аж байдлыг доройтуулсан байна. Хэдий тийм боловч Монголын ард түмэн тусгаар тогтносон улсаа байгуулбал харийн ба нийгмийн дарлалаас үүрд ангижирч, түмэн жилийн жаргал эдлэх юм шигээр ойлгож, хамаг мал хөрөнгөө цэргийн хэрэгцээнд нийлүүлж байв.

Гэвч Өвөр Монголыг чөлөөлөх тэмцлийг хоёр хөршийн бодлогын улмаас зогсоохоос өөр аргагүй байдалд хүрсэн юм. Тиймээс 1911 оны Үндэсний эрх

чөлөөний хувьсгалын нэгэн зорилт болсон нийт монгол овогтноо нэгтгэсэн Их Монгол улсаа байгуулах гэсэн санаа, эрмэлзлэл талаар өнгөрсөн юм. Мөн улмаар байлдан олсон төрийнхөө бүрэн эрхт байдлыг 1915 онд хязгаарлуулхад хүрсэн амуй.

Түлхүүр үг: Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Монгол төрийн бүрэн эрхт байдал, Их Монгол, үндэсний үзэл, улс төр судлал

Товч хураангуй: Энэхүү өгүүлэлд 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ялалтаар байгуулагдсан Олноо өргөгдсөн Монгол улсын төрийн хүлээн зөвшөөрөгдсөн байдал хийгээд нийгмийн зүгээс тус тулгар тогтсон төр, засгийг хэрхэн үзэж байсан талаар тухайн үеийн түүхийн эх сурвалжууд дээр тулгуурлан гарган бичсэн болно. Чингэхдээ 1911 оны үйл явдлыг яагаад хувьсгал хэмээн үзэж байгааг мөн илтгэхийн ялдамд уг хувьсгалын зорилтууд юунд оршиж байв, тэдгээр нь хэрхэн хэрэгжсэн талаар бичсэн амуй.

ABSTRACT

In this article described how "all elevated Mongolia" was proclaimed and it was recognized by the Mongolian society and it was described by the historical sources of that time. An author give her explanation why we should name 1911' events as a revolution and what main purposes were of that revolution and how it was implemented during the revolution.